# Газар хөдлөлтөд бэлдэцгээе

- ☐ Гэрийн тавилгаа бөхлөх



- ☐ Гамшгийн үеийн цүнх бэлдэх



- ☐ Ус, идэх зүйлсийг нөөцлөх



- ☐ Хоргодох газар болон зугтах замыг мэдэж авах



- ☐ Газар хөдлөлт мэдрэгч суурилуулах




- ☐ Барилга байгууламжийг газар хөдлөлтөд тэсвэртэй болгож хүчитгэх



**Өөрийн болон хайртай хүмүүсийнхээ амь насыг хамгаалахын төлөө одооноос бэлдэцгээе**

---

（Мэдэгдэх нөхцөл）

## “Нанкай Трап” газар хөдлөлтийн талаарх түр зуурын мэдээлэл

- **“Нанкай Трап” дагуу ер бусын үзэгдэл ажиглагдаж, “Нанкай Трап” -тай холбоотой эсэхийг судалж эхэлсэн бол, эсвэл үргэлжлүүлэн судалж байгаа бол**
- **Ер бусын үзэгдэл ажиглагдсан судалгааны үр дүнг зарлах бол**

| Түлхүүр үг | |
|---|---|
| Судалж байна | Ер бусын үзэгдэл ажиглагдсан нь “Нанкай Трап” дагуух томоохон газар хөдлөлттэй хамааралтай эсэхийг судалж эхэлсэн бол, эсвэл үргэлжлүүлэн судалж байгаа бол |
| Асар хүчтэй газар хөдлөлтөөс сэрэмжил | “Нанкай Трап” дагуух газар хөдлөлтийн голомтын таамагласан бүсэд M8.0 ба түүнээс дээш газар хөдлөлт болсон гэж дүгнэсэн бол |
| Асар хүчтэй газар хөдлөлтөөс болгоомжил | “Нанкай Трап” дагуух газар хөдлөлтийн голомтын таамагласан бүсэд M7.0 ба түүнээс дээш, M 8.0-аас доош газар хөдлөлт болсон гэж дүгнэсэн бол<br>Газар хөдлөлтийн голомтын таамагласан бүсийн хавтангийн хилийн гадна болон газар хөдлөлтийн голомтын таамагласан тэнхлэгээс гадна 50 км орчмын зайд M 7.0 ба түүнээс дээш газар хөдлөлт болсон гэж дүгнэсэн бол<br>“Нанкай Трап” дагуух газар хөдлөлтийн голомтын таамагласан бүсэд M8.0 ба түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт болсон гэж дүгнэсэн бол |
| Судалж дууссан | Асар хүчтэй газар хөдлөлтөөс болгоомжил, асар хүчтэй газар хөдлөлтөөс сэрэмжил гэдгийн аль нэгэнд хамаарахгүй үзэгдэл гэж дүгнэсэн бол |

## “Нанкай Трап” газар хөдлөлтэй холбоотой тайлбар мэдээлэл

- **Ерийн бус үзэгдэл ажиглагдсан судалгааны үр дүнг мэдээллэсний дараа нөхцөл байдлын явцыг зарлах бол**
- **“Нанкай Трап дагуух газар хөдлөлтийн үнэлгээний хурал” -р судалгааны дүнг зарлах бол (онцгой мэдээлэл зарлахаас бусад)**

---

## Холбогдох хаяг


内閣府 Cabinet Office

Засгын газрын бодлогын дарга
（Гамшгаас урьдчилан сэргийлэх ажил хариуцсан）
Зөвлөгч（Судалгаа, төлөвлөлт хариуцсан）
〒100-8914　Токио хотын Чиёдо дүүргийн Нагата-чо 1-6-1
Захиргааны нэгдсэн төвийн 8-р байр
TEL：03-5253-2111（Гол төлөөлөгч）　FAX：03-3501-6820
Засгын газрын хэрэг эрхлэх газар вэб хуудас URL：
https://www.bousai.go.jp/jishin/nankai

気象庁 Japan Meteorological Agency

Японы цаг уурын агентлаг хөдлөлт, галт уулын хэсэг
〒105-8431　Токио хотын Минато дүүргийн Тораномон 3-6-9
Утасны дугаар: 03-6758-3900(төлөөлөгч)　FAX：03-3434-9086
Цаг уурын агентлагын вэб хуудас URL：
https://www.data.jma.go.jp/eqev/data/nteq/index.html


Хэвлэсэн огноо 2025 оны 2 сар

# “Нанкай Трап” /Nankai Trough/ газар хөдлөлт

## -Тэр үед бэлдэх-

**Мэдлэгтэй байснаар та өөрийгөө болон таны хайртай хүмүүсийн амь насыг аварна**

**“Нанкай Трап” газар хөдлөлт гэж Суруга булангаас Хюганонада хүртэл үргэлжлэх хавтангийн хилийг газар хөдлөлтийн бүсийг хэлэх бөгөөд эдүгээ асар их хэмжээний хохирол учруулсаар ирсэн томоохон газар хөдлөлт юм.**

## Дараагийн “Нанкай Трап” газар хөдлөлт хэзээ ч тохиолдож болно.




**!** Газар хөдлөлтийн хамгийн их хүч 7 балл — **7**

**!** Үүсэх магадлалтай цунамигийн өндөр: Хамгийн өндөртөө **30** м-ээс дээш

